


# APU COMPANY

Absolute. Pure. Unique.

Хувьцааны арилжааны мэдээлэл	
2023 оны 9-р сарын 4	MSE:APU
Хаалтын ханш (2023.09.04):	₮ 1,249
52 долоо хоног:	₮ 1,245 – 1,543
Нийт гаргасан тоо ширхэг:	1,064,181,553
Зах зээлийн үнэлгээ:	₮ 1,327,655,454,007

## ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ТҮҮХ

Эх сурвалж: МХБ




## ГОЛЛОХ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД\*

Үнэ-ашгийн харьцаа (P/E)	11.6
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	2.0
Нэгж хувьцаанд ногдох ашиг	₮108
Хөрөнгө оруулалтын өгөөж	17.3%

Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Эх сурвалж: МХБ



## КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК нь 1924 оноос шингэн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа тууштай явуулж буй Монголын ууган үйлдвэрлэгч компани юм. Тус компани Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 1927 онд шар айраг үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд Монголын хамгийн анхны хар шар айргийг 1940 онд үйлдвэрлэсэн байна. АПУ ХК нь дотоодын согтууруулах ундааны болон шар айргийн зах зээлд тэргүүлэх байр суурьтай бөгөөд нийт есөн охин компани, нэг хараат компанитайгаар үйл ажиллагаа явуулж байна.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн 56.09 хувийг Шунхлай Холдинг ХХК, 25.03 хувийг Heineken Asia Pacific PTE Ltd, 10.76 хувийг Steppe Beverage KFT тус тус эзэмшдэг. Мөн 8.16 хувийг олон нийтэд санал болгосон ба нийт 1,064,181,533 тоо ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээл дээр арилжаалж байна.

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

АПУ ХК нь нийт 2309 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж, 10 мянга гаруй харилцагчдынхаа хамтаар, 371 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын зах зээлд борлуулалдаг. АПУ ХК нь Монгол Улсын шингэн хүнсний зах зээлд тэргүүлэгч компани юм. Тухайлбал, тус компани нь нийт архины болон шар айргийн зах зээлийн 83 болон 93 гаруй хувийг тус тус бүрдүүлж байна. Харин бусад бүтээгдэхүүний хувьд зах зээлийн 3-30 хувийг эзэмшиж байгаа бөгөөд компани нь эдгээр зах зээл дээр тэлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

## БОРЛУУЛАЛТ:

2023 оны эхний хагас жилийн байдлаар компанийн борлуулалтын тоо хэмжээ 86 сая литр буюу өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар өссөн бол борлуулалтын оролго өмнөх оны мөн үеэс 32.4 хувиар өссөн бөгөөд цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс 13 хувиар буурчээ. Борлуулалтын орлого өсөхөд сүү сүүн бүтээгдэхүүний борлуулалт, Дижитал концепт ХХК болон экспортын борлуулалт өндөр байсан нь голлон нөлөөлжээ.

Харин ашигт ажиллагаа буурахад хүний нөөц болон байгаль орчин нийгэм рүү чиглэсэн төсөл хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

## ЭКСПОРТ РУУ ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА


2023 оны эхний хагас жилийн байдлаар Казакстан улс руу экспорт хийх гэрээ байгуулан ажиллаж байна. ОХУ-ын Москва, Санкт Петербург хотод Чингис Хаан брэндийг таниулан борлуулж эхэлсэн. Цар тахлын дараа БНХАУ-ын хил нээгдсэнтэй холбоотой Сэнгүр Брэндээ хэрэглэгчдэдээ дахин таниулах, дахин хүргэх ажлыг хэргэжүүлсэн. Олон улсын Duty Free сүлжээ дэлгүүрүүдэд өөрсдийн бүтээгдэхүүнийг борлуулах хүрээнд Тайланд улсын King Power компанитай хамтран ажиллаж Тайландын Duty Free-р Чингис Хаан, Соёмбо, Эден брэндүүдийг борлуулж байна.

## САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны эхний хагас жилийн байдлаар эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 23.5 хувиар өсөж 433.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд харилцагч нараа дэмжих, экспортын үйл ажиллагааг тэлэх бодлогыг үргэлжлүүлснээр авлагын дүн нэмэгдсэн ба бараа материалын нөөцийн өсөлт, хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотойгоор эргэлтийн хөрөнгө өнгөрсөн оноос өсжээ. Бараа материалын нөөц нэмэгдэхэд хөрөнгө оруулалттай холбоотой харилцагч бэлтгэн нийлүүлэгчдэд өгсөн урьдчилгаа, борлуулалтын үйл ажиллагаа, мөн улирлын циклтэй холбоотой түүхий эд материалыг нөөцлөхтэй холбоотой эргэлтийн хөрөнгө нэмэгджээ.


## БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (тэрбум төгрөг)

Эх сурвалж: МХБ




## ЦЭВЭР АШИГ (тэрбум төгрөг)

Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол




## НИЙТ ХӨРӨНГӨ (тэрбум төгрөг)

Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол



## ХӨРӨНГИЙН БҮТЭЦ

Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол



## САНХҮҮЖИЛТИЙН БҮТЭЦ

Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол

